



ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-221, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090
Утас: 70593399 Факс: 70593399

Цахим шуудан: info@procurement.du.gov.mn
Цахим хуудас: https://@procurement.du.gov.mn

2024.10.30 № 24/139

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны 08 дугаар сарын 29-ны өдөр баталсан “Худалдан авах ажиллагаа болон цахим системд хяналт хийх” удирдамжийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 13-ны өдрүүдэд аймгийн зарим сумдад ажилласан бөгөөд нийтлэг зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан тогтоолын дагуу төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралт маягтын дагуу төлөвлөж цахим системд ил тод нийтлэх.
2. Үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн захиалагчийн эрх үүрэг, мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1.”100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй”, 50.1.2.”ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй.” байна гэсэн заалтын аль тохирохыг сонгох.
3. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7 “Захиалагч өөрийн ажилтан, албан хаагч бус мэргэшсэн ажилтныг үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан бол үнэлгээний хорооны хуралд оролцсон цаг тутамд Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн ТЗ-7, ТЗ-6 албан тушаалын зэрэглэлийн 1 цагтай тэнцэх хэмжээний урамшууллыг тооцон өөрийн төсөвт багтаан олгоно.” гэж заасны дагуу бусад байгууллагаас ажиллуулсан үнэлгээний хорооны гишүүдэд урамшууллыг олгож ажиллах.
4. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын хавсралт маягтаар гаргах.
5. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.2.5.”үнэлгээний хороо захиалагчийн шийдвэр, тендертэй холбоотой тодруулгыг цахим системд бүрэн нийтэлснээр тендер шалгаруулалтын үр дүн нийтлэгдэх бөгөөд шалгарсан оролцогчийн

- хойш ажлын таван өдрийн хугацаанд цахим системээр бусад оролцогчид ил болгох” зэрэг заалтыг анхаарч ажиллах.
6. Мөн дээрх журмын 3.3.”Мэргэжлийн байгууллага хуулийн 8.2-т заасан жагсаалтад орсон барааг ерөнхий гэрээний аргын дагуу сонгон шалгаруулж, цахим дэлгүүрт байршуулан, тухайн барааг шууд худалдан авах боломжоор захиалагчийг хангаж болно.” гэж заасны дагуу ерөнхий гэрээнд тусгагдсан барааг цахим дэлгүүрээс худалдан авах.
 7. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийг ашиглах, шалгуур үзүүлэлтийг төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон барааны онцлог, цар хүрээнд нийцүүлэн уялдуулахаас гадна сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материалын үнийг сумын зах зээлийн үнэ болон орон нутгийн бараа бүтээгдэхүүний үнэтэй уялдуулан тооцоо судалгааг гарган боловсруулж тендер зарлах, тендерийг зарласан тухай олон нийтэд мэдэгдэх.
 8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 48.5-т заасны дагуу захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах, оролцогчийн цахим тендерийн материалыг хэвлэхгүйгээр (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгална архивлах.
 9. Оролцогчийн тендерийн хянан үзэхдээ Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар” журмын хавсралт маягт 1, 2, 3, 4, 5, 6, захиалагчийн шийдвэрийг маягт 8, 9, 10-аар хүргүүлэх.
 10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.”Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна.” гэж заасны дагуу шалгарсан оролцогчтой байгуулсан гэрээ, шууд худалдан авах аргыг хэрэглэн зохион байгуулсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд тухай бүр нийтлэх зэргийг анхаарч ажиллана уу.



Дундговь аймгийн Худалдан авах ажиллагааны
газар
Удирдлага
Дарга
Батсайхан АДЪЯАСҮРЭН
2024-10-30 18:28:02